



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 09 сарын 11 өдөр

Дугаар А/1105

Улаанбаатар хот

Г Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн  
барилга данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 139 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1105 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол улсын төсвийн хөрөнгөөр 2020 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтын XVIII.1.1 Ахмад настан, хүүхдийн эмнэлгийн барилга шинээр барих болсонтой холбогдуулан барилгын техникийн хяналтын улсын байцаагчийн 2018 оны 02-07-395/1093 дугаар дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй болох нь тогтоогдсон Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн балансад бүртгэлтэй 181,076,677.86 /нэг зуун наян нэгэн сая далан зургаан мянга зургаан зуун далан долоон төгрөг наян зургаан мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий барилга, байгууламж, нийтийн эзэмшлийн хөрөнгийг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасаж, өмчийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний өөрчлөлт хийж ажиллахыг Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төв /Ж.Энхзуул/-д зөвшөөрсүгэй.


2. Данснаас хасагдаж буй барилгын хоёрдогч түүхий эдийн зориулалтаар дахин ашиглах боломжтой хөрөнгийг худалдан борлуулахаар үнэлсэн 3,934,600 /гурван сая есөн зуун гучин дөрвөн мянга зургаан зуу/ төгрөгийг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд төвлөрүүлж, акт болон бусад баримт бичгийн бүрдэлд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /Д.Төмөрбаатар/-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.РЭНЦЭНБЯМБА



Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын  
даргын 2020 оны 29... дүгээр сарын 11...-ний  
өдрийн 1157 дугаар тушаалын хавсралт

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ БАРИЛГА,  
БАЙГУУЛАМЖ, НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ХӨРӨНГӨ

Төгрөгөөр

№	Эд хөрөнгийн дүн	Ашигласан жил	Хэмжих нэгж	Биет хэмжээс /м²/	Нэгжийн үнэ	Бүртгэлийн үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэх өртөг
1	Амбулатори 2 барилга	38	M2	1760	176,848,957.86	176,848,957.86	33,159,179.52	143,689,778.34
2	Амбулатори 2 автомашины зогсоол	38	M2	50	4,161,600.00	4,161,600.00	891,771.48	3,269,828.52
3	Хайс	38	M2	20	66,120.00	66,120.00	66,120.00	-
<b>Нийт үнэ</b>						<b>181,076,677.86</b>	<b>34,117,071.00</b>	<b>146,959,606.86</b>